



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 397

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслөөс санхүүжүүлэн 2019 онд барьж ашиглалтад оруулсан нийт 816,688,253.50 (найман зуун арван зургаан сая зургаан зуун наян найман мянга хоёр зуун тавин гурван төгрөг тавин мөнгө) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн захирал Д.Батмөнх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Төслийн хөрөнгө оруулалтаар бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайландаа тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Барилгын доорх газар эзэмших эрхийг баталгаажуулах, үнэлж бүртгэлд тусгах арга хэмжээ авах;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

*Д.Нарангэрэл*

Д.НАРАНГЭРЭЛ

132001318

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн  
—22 дугаар тоогоорын хавсралт

Байгаль, орчин аялал жуулчлалын яамны үндсэн хөрөнгөд буртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Барилгын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /төгрөгөөр/ Улсын комиссын актын дугаар
1	Байгаль хамгаалагч, судалгааны байр /ТӨВ аймаг Аргалант сум/	2 давхар, 700 м <sup>2</sup>	816,688,253.50 ББКД-87/19
		<b>Нийт дүн</b>  <b>816,688,253.50</b>	/ найман зуун арван зургаан сая зураган зуун наян найман мянга хоёр зуун тавин гурван төгрөг тавин мөнгө /